

Төслийн мэдээллийн тайлангийн энэхүү орчуулсан хувь нь 2017 оны 4-р сарын 10-ны байдлаарх англи эхэд суурилсан болно.



ASIAN DEVELOPMENT BANK

## Монгол Улс: Эдийн засгийн хүндрэлтэй үед чанартай боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл

Төслийн нэр	Эдийн засгийн хүндрэлтэй үед чанартай боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх нь	
Төслийн дугаар	50091-002	
Төсөл хэрэгжих улс	Монгол Улс	
Төслийн статус	Боловсруулж буй	
Төслийн төрөл / Дэмжлэгийн хэлбэр	Зээл	
Санхүүжилтийн эх үүсвэр / Мөнгөн дүн	<b>Зээл: Эдийн засгийн хүндрэлтэй үед чанартай боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх нь</b>	
	Ердийн хөрөнгийн эх үүсвэр	50.00 сая ам.доллар
Холбогдох стратегийн зорилт	Байгальд ээлтэй тогтвортой өсөлт Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт	
Өөрчлөлтийг чиглүүлэгч салбарууд	Засаглал ба чадавхи бэхжүүлэх Мэдлэгт суурилсан шийдлүүд Түншлэл	
Салбар / Дэд салбар	<b>Боловсрол</b> - сургуулийн өмнөх, дунд болон бүрэн дунд боловсрол	
Жендэрийн тэгш эрх ба жендэрийн үзэл баримтлалыг төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үр өгөөжтэй нэвтрүүлсэн	
Төслийн товч агуулга	2011 онд огцом өсөлттэй байсан Монголын эдийн засаг гадаадын шууд хөрөнгө оруулалт болон бараа таваарын үнэ буурснаас үүдэн саарч байна. Эдийн засгийн өсөлт буурснаас үүдэн эдийн засагт ноцтой хүндрэлүүд бий болж байна. Тухайлбал, төсвийн алдагдал ихэсч төсвийн хөрөнгө оруулалт буурч буй бөгөөд энэ нь 2018 онд ч үргэлжлэх төлөвтэй байгаа тул төсвийн алдагдлыг бууруулахын тулд зардал хумих шаардлагатай байна. Үүний сөрөг үр дагавар	

боловсролын салбарт аль хэдийн мэдрэгдэж эхэлжээ. Тухайлбал, мэргэжлийн боловсролын сургуулийн оюутанд сар бүр олгодог байсан мөнгөн тэтгэмж зогссоноос хойш дунд ангийн сурагчид сургуулиа орхих явдал ихэссэн байна. Боловсролын төсвийг хумьсан мөн түүнчлэн сургуулийн насны хүүхдийн тоо олширч, сургууль, цэцэрлэгийн урсгал зардал өссөн нь боловсролын, ялангуяа эмзэг бүлгийн сурагчдын боловсролын чанар, хүртээмжийг хадгалж үлдэхэд улам хүндрэлтэй болгож байна. Энэ асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхийг Засгийн газар АХБ-наас хүссэн юм.

Төсвийн зардлыг бууруулсан нь хүүхдийн тоо нь хэтэрч олон ээлжтэйгээр хичээллэж байсан сургууль, цэцэрлэгт ихээхэн дарамт учруулж байна. Үүний улмаас хүүхдүүд сургууль, цэцэрлэгт орж чадахгүй байх нөхцөл бий болсон. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд шилжин ирэх хөдөлгөөнөөс үүдэн анги дүүргэлт хэмжээнээсээ хэтэрч сургуулиуд хоёроос гурван ээлжээр хичээллэж байна. Түүнчлэн, Улаанбаатарын захын дүүргийн сургуулиудад орчин нөхцөл бүрдээгүй учир ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургууль завсардаж байна.

Боловсролын төсвийг хумьсанаар боловсролд зарцуулах үндсэн зардлыг багасгаж улмаар сурлагын чанарт муугаар нөлөөлөх байдал бий болсон. Засгийн газар сургууль, цэцэрлэгийн цалин, урсгал зардлыг арай ядан төлж байгаа үед сурах бичиг, сургалтын материал, тоног төхөөрөмжийн хангамж асар бага байх болно. Сургуульд хангалттай сургалтын материал, сурах бичиг, номын сан, шинжлэх ухааны лаборатори, хангамж байдаггүй тул нэн ялангуяа лаборатори бус сургуулиудад лаборатори сургуулиудыг бодвол илүү хүнд тусах болно.

Боловсролын салбарын төсвийн хомсдол нь төсөв муутай сургуулиудын ахлах ангийн сурагчдын хөтөлбөр сонгон суралцах боломжийг хязгаарлана. Сургууль завсардаж буй хүүхдийн тоо (ихэвчлэн ядуу, малчин, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, эрэгтэй хүүхдүүд) эдийн засгийн хүндрэлтэй үед улам өсч, эдгээр хүүхдэд хувилбарт сургалтаар л боловсрол эзэмших тул тэдний ирээдүйн амжилтад сөргөөр нөлөөлөх болно.

Багшийн сургалт, мэргэжлийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалт дутагдалтай явдал нь сурлагын чанар, боловсролын хүртээмжид нөлөөлнө. Сүүлд нэвтрүүлсэн сургалтын цөм хөтөлбөрийн хүрээнд нэвтрүүлсэн хүүхэд төвтэй сургалтын аргачлалыг бага, дунд сургуулийн олон багш нар хараахан бүрэн эзэмшээгүй байгаа юм. Сургууль завсардсан хүүхэд, залуучуудад зориулсан сургуулиас гадуурх боловсрол олгох хувилбарт сургалтын хөтөлбөрүүдийн чанар муу байдаг гол шалтгаан нь насан түршийн боловсрол олгох төвийн багш нарыг сургалтанд бараг хамруулдаггүйтэй холбоотой юм. Түүнчлэн, багшийн сургалтанд зориулсан төсөв дутагдалтай байдал нь угийн боловсон хүчин

---

дутагдалтай байдаг цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэшсэн багш, ажилчид байхгүй учир хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах Засгийн газрын хүчин чармайлтад саад учруулж байна.

**Төслийн үндэслэл ба Улс/Бүс нутгийн стратегитэй уялдсан байдал**

1991 оноос эхлэн АХБ нь дараах чиглэлээр дэмжлэг үзүүлж ирсэн, үүнд: (i) Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед суурь боловсролын тогтолцоог хөгжүүлэх, чанарыг сайжруулах үндсийг бэхжүүлэх; (ii) олон улсын жишигт нийцүүлэн 10 жилийн сургалтын системийг 12 жил болгон шилжүүлэх; (iii) санхүүгийн хямралын үед сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, бага насны хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, хүнс, тэжээлийг сайжруулах чиглэлээр ажиллаж ирсэн. Эдгээр туршлага болон одоо АХБ-ны боловсролын салбарт явуулж байгаа үйл ажиллагаанд уг төсөл үндэслэх юм. Төсөл нь АХБ-ны 2014 -2016 онуудад хэрэгжүүлэх АХБ ба Монгол улсын Хамтын түншлэлийн стратегийн хоёр тулгуурын нэг болох цогц нийгмийг хөгжүүлэх, гол салбар болох суурь, дунд боловсролыг хөгжүүлэх бодлоготой тус тус нийцэж байгаа юм.

**Төслийн үр нөлөө**

Чанартай суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхдийн тоо нэмэгдсэн байна.

**Төслийн үр дүн**

Эдийн засгийн хүндрэлтэй үед чанартай суурь болон бүрэн дунд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх.

**Төслийн үр дүн, үйл ажиллагаа**

Сургууль, цэцэрлэгийн багтаамж нэмэгдсэн байх.  
Боловсрол олгох чанартай сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдсэн, түүнийг эзэмших, авах боломж нэмэгдсэн байх.  
Багшийн мэдлэг, чадвар сайжирсан байх.  
Боловсролын салбарын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх систем боловсруулсан байх.

**Газарзүйн байршил**

**Хамгааллын бодлогын ангиллууд**

Байгаль орчин

В

Албадан нүүлгэн шилжүүлэлт

С

Уугуул иргэд

С

**Байгаль орчин болон нийгмийн асуудлуудын хураангуй**

Байгаль орчин

Албадан нүүлгэн шилжүүлэлт

## Уугуул иргэд

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба хэлэлцүүлэг

Төслийн төлөвлөлтийн үед

Төслийн хэрэгжилтийн үед

## Хариуцагч талууд

АХБ-ны хариуцсан ажилтан	Асако Маруяама
АХБ-ны хариуцсан газар	Зүүн Азийн Газар
АХБ-ны хариуцсан хэлтэс	Зүүн Азийн Газрын Хот байгуулалт ба нийгмийн салбарын хэлтэс
Хэрэгжүүлэгч байгууллага	<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам</b> Засгийн газрын III байр, 514 тоот, Бага тойруу-44, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс

## Цагалбар

Концепцийг баталсан огноо	2016 оны 11 сарын 03
Баримт цуглуулах судалгаа хийгдсэн хугацаа	2017 оны 03 сарын 13-24
Удирдлагын хянан хэлэлцэх хурлын огноо	2017 оны 04 сарын 12
Төсөл батлагдсан огноо	-
Сүүлд хийгдсэн төслийн хяналт	-
Төслийн мэдээллийн тайланг шинэчилсэн огноо	2017 оны 03 сарын 26

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)-д төсөл, хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл агуулагддаг бөгөөд энэхүү баримт нь амьд баримт бичиг тул зарим нэг мэдээлэл тайлангийн эхний хувилбарт тусгагдаагүй ч дараагийн хувилбарт орж болно. Санал болгож буй (батлагдаагүй) төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)-г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа баталгааг олгохгүй. АХБ-ны зүгээс агуулгын чанарт ихээхэн анхаардаг хэдий ч энэхүү тайланд агуулагдсан мэдээллийг “байгаагаар нь” буюу арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэнд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүйгээр толилуулж байна. АХБ нь тайлан дахь мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлын талаарх ямар нэгэн баталгаа, эсхүл мэдэгдэл хийгээгүй болно.